



**Хүйсийн тэгш эрхийн төв**

LOGO

ILO/IPEC

# **НИЙГМИЙН СУДАЛГАА АВАХДАА АНХААРАХ ЁС ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААР БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Улаанбаатар хот

## **Судалгааны ёс зүйн зарчмууд ба удирдамж**

Амьдралын асуудал хөндсөн аливаа судалгааны хувьд ёс зүйн ойлголтууд тэргүүлэх зэргийн ач холбогдолтой байдаг. Нийгмийн онцгойлсон судалгаа хийхдээ баталгаатай, чанартай мэдээллээр хангах арга замыг хайж олохын зэрэгцээ тэдний санаа бодол, шулуун шударга байдлыг хүндэтгэн үзэхгүй байх, тэднийг ашиглах болон хувийн нууцад нь халдах зэргээс хамгаалах шаардлагатай байдаг.

## **Ёс зүй ба судалгаа**

Бүх төрлийн судалгаанд ёс зүйн дүрэм журмууд баримтлагдах ёстой. Аливаа нийгмийн судалгаа нь эхнээсээ л оролцогчиддоо (судалгаа хийж байгаа хүмүүс өөрсөддөө ч мөн) хохирол учруулах явдлыг цээрлэх ёстой. Тиймээс нийгмийн судалгаа нь оролцож буй хүмүүстээ эсрэгээр нөлөөлөхгүй байх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрэв судалгаа нь ямар нэг байдлаар оролцож байгаа хүмүүсийн эрх ашгийг хөндөх нь илэрхий болбол уг судалгааг зогсоох нь зүйтэй алхам болно.

Судалгааны баг гол үйл ажиллагаагаа явуулахдаа мөн хамгийн чухал ёс зүйн асуудлуудыг тусгаж чадаж байгаа эсэхдээ баттай байхын тулд шалгах хуудас бичиж мөрдөх нь түгээмэл байдаг. Ёс зүйн ойлголтуудыг алхам тутамдаа, үе шат болгондоо тусгаж явах ёстой. Судалгааны зорилгыг танилцуулах, мэдээлэл авахаас эхлэн судалгаанд оролцох хүмүүс, хүн амын суурьшиж буй орон нутаг, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг сонгох, оролцогчдоос асуулга авах зөвшөөрлийг нь авах, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх зэрэгт ч ёс зүйн асуудлууд үүсдэг, эдгээрт тэднийг тусгах ёстой байдаг.

Ёс зүйтэй судалгаа нь дараагийн тодорхой нийтлэг хэм хэмжээг шаарддаг ч эдгээр нь бас хангалттай биш байдаг. Ёс зүйтэй судалгаа нь тус багийг цаг үргэлж нөхцөл байдлаа мэдэрч байхыг шаарддаг ба судалгааны явцад үүсэх ёс зүйн хэцүү асуудлуудад аль болох бэлтгэлтэй, хариуцлагатай хандахыг шаарддаг.

Нийгмийн судалгаанд мөрдөгдөх ёс зүйд судалгаанд хамруулах, судалгаанд оролцогчдоос зөвшөөрөл авах, хувийн мэдээлэл нууцлах, нэр нууцлах болон хүндэтгэх (ёс заншил уламжлал, тухайн нийгмийн бүлгийн ёс заншлыг хүндэтгэх) асуудлууд багтана.

## Судалгаанд хүүхдүүдийг хамруулах нь

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци хүүхдийн оролцооны эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Тодруулбал зүйл 12-д хүүхдийн өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх эрх, тэдэнд хамаатай ямар ч асуудалд тэдний энэ үзэл бодлыг тусгах тухай дурьдсан байдаг бол Зүйл 13-д хүүхдийн өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх эрх чөлөө, тэдэнтэй хамаатай асуудлаар мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан байдаг. Өөрт нь хамаатай ямар ч асуудалд оролцох гэдэг нь судалгаанд оролцох эрхтэй гэдгийг тодорхой өгүүлж байна. Өөрсдөд нь хамаатай судалгаанд хүүхдүүдийг оролцуулах асуудал нь ёс зүйтэй судалгааны төлөвлөгөөний салшгүй чухал хэсэг юм.

Хүүхдийн оролцооны эрх нь тэдний төрөлхийн эрхэд тооцогдохоос гадна илүү их хамааралтай мэдээлэл олж авахын тулд хүүхдүүдийг судалгаанд оролцуулах явдлыг улам бүр дэмжих болсон бөгөөд хэрэв судалгааны бодлого болон хөтөлбөр нь хүүхдийн хэрэгцээ шаардлагыг илүү их хамаарч тэдний асуудлыг шийдэх хэмжээнд хийгдсэн бол тэднийг судалгаанд оролцуулах хэрэгтэй гэж үздэг. (Boyden and Ennew, 1997, 10).

Хүүхдүүдэд тусгай хамгаалалт хэрэгтэй байдаг гэдэг нь тэдний судалгаанд оролцох эрх болон идэвхтэй оролцогчид байх эрхийг нь хасна гэсэн үг биш.

“Хүүхдүүд юмыг өөр өөр нүдээр хардаг, тэд өөр өөр асуулт асуудаг. Тэд томчуулын бодолд ч орж ирэхгүй зүйлийг асуудаг, тэдний санааг өөр өөр зүйл зовоодог, тэд томчуулын нэвтэрч чаддаггүй үеийнхээ хүүхдүүдийн өвөрмөц ёс заншлыг маш хурдан хүлээж авдаг.” (Kellet, 2005)

Хүүхдээс судалгаа авахад **туршилт** маш чухал, яагаад гэвэл бидний хэрэглэж байгаа хандлага, арга хэрэгсэл, хэллэг болон бусад зүйлсээс үүсч болох хүндрэлүүдийг тодруулах боломжийг бий болгодог. Мөн асуулт асууж байгаа хэв маяг, асуултанд хэрэглэж байгаа үг хэллэг, болон судалгааны бусад талыг хүүхдийн оролцоо өөрчлөх эсэхийг тодорхой болгодог.

## Мэдээллийн үндсэн дээр зөвшөөрөх

Насанд хүрэгчид болон хүүхэд (судалгааны зорилтот бүлэг) судалгаанд оролцох эсэхээ өөрсдөө шийдэх эрхтэй. Тэдний шийдвэр судалгааны багаас өгч байгаа гол мэдээлэл дээр тулгуурлах бөгөөд энэ нь тэдэнд хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт суурилна. Энэ нь мэдээлэлд суурилсан шийдвэр буюу мэдээлэлд суурилсан зөвшөөрөл өгөх боломж олгоно.

Зөвшөөрөл авах нь судалгааны (нийгмийн, анагаахын болон өөр бусад) гол цөм болсон хувь хүнд хүндэтгэлтэй ёс зүйтэй хандах хандлагын үндэс мөн.

**Нийгмийн судалгаа нь:** мэдээлэл болон тоо баримт цуглуулах зорилготой байдаг. Судалгаанд оролцогчид тухайн мэдээллийг өгөх эсэхээ шийдэх эрхтэй байдаг. Хэрэв тэд мэдээллийг өгөхгүй гэж шийдвэл яагаад гэдэг шалтгааныг судалгаа явуулж байгаа хүн асууж тодруулах эрхгүй.

Хүүхдэд ч судалгаанд оролцохоос татгалзах эрх бий. Гэвч хүүхдүүдээс оролцох зөвшөөрөл авахад тодорхой хүндрэлүүд гардаг. Тэднээс зүгээр л “Чи энэ судалгаанд оролцохыг хүсч байна уу, үгүй юү?” гэж асуух нь хангалттай бус. Оролцогчийн зөвшөөрөх эсэх нь тэднээс юу хүлээгдэж байгааг ойлгосон, судалгаа нь тэдэнд ямар нөлөө үзүүлж болохыг урьдчилан харах чадвараас нь хамаардаг. Ирээдүйд юу болохыг таах нь зарим хүүхдүүдэд хэцүү байдаг.

Судалгааг жинхэнэ ёс зүйтэй явуулна гэдэг оролцогчдоос зөвхөн судалгаанд оролцохыг хүсч байгаа эсэхийг нь албан ёсоор асуух явдал биш гэдгийг байнга санаж байх ёстой.

Энэ бол тухайн хүнд шаардлагатай мэдээллийг нь өгсний дараа эцсийн шийдвэрийг тэр өөрөө гаргана гэдгийг ойлгуулах явдал юм.

Хүүхдүүдээс зөвшөөрөл авахдаа мөн эцэг эхээс нь давхар зөвшөөрөл авах хэрэгтэй. Гэвч эцэг эх нь зөвшөөрөхгүй, хүүхэд өөрөө зөвшөөрвөл ёс зүйн маргаантай асуудал гарч ирэх магадлалтай. Судалгааны багийн асуулга авч байгаа бүх хүн судалгаанд оролцох хүүхдүүд болон өсвөр насны хүүхдүүдээс судалгаанд оролцох зөвшөөрлийг нь авах хэрэгтэй. Судалгааны зорилгыг тайлбарласан үндсэн мэдээлэл болон хүүхдүүд ямар

эрхтэй байдгийг тайлбарлаж таниулсны дараа л хүүхдээс судалгаанд оролцох зөвшөөрлийг нь авбал зохино.

### **Нэмэлт асуудал**

Судалгаанд оролцох хүмүүстэй харьцаж байгаа хэл яриа, үг хэллэг тэргүүлэх ач холбогдолтой. Үндсэн мэдээллээ танилцуулах, тэдний судалгаанд оролцох эсэхийг нь асуухдаа тухайн бүлгийн онцлогийг харуулахуйц хэл яриа хэрэглэхээр шийдсэн бол судалгаанд хамрагдах тухайн бүлгийн хүмүүсийг урьж саналыг нь асуух хэрэгтэй.

Ямар хэл яриа хэрэглэвэл энгийн ойлгомжтой болохыг хамтран хэлэлц. Зөвхөн тухайн бүлгийн ойлгодог, тэдний логикт тохирсон хэл яриаг хэрэглэх нь илүү зохимжтой эсэх талаар ярилцаж, шийтгдвэрээ гаргах хэрэгтэй.

### **Хувийн мэдээлэл болон нэр нууцлах**

Нийгмийн судалгаанууд бүхэлдээ судалгааны үр дүнг баттай байлгах үүднээс оролцогчдын нэр болон хүмүүст танигдах хувийн мэдээллийг нь шаардаж авдаггүй. Судалгаанд оролцогчдод хандах ёс зүйн нэг чухал хэсэг бол тайландаа **оролцогчдын хувийн мэдээллийг оруулахгүй** байх гэсэн зарчим юм.

Үүний зорилго нь оролцогчдыг хамгаалах асуудал бөгөөд судалгаанд оролцсоны дараа тэднийг ялгаварлахгүй байх эсвэл тэдний өгсөн мэдээллийг тэдний эсрэг ямар ч буруутгасан болон эсэргүүцсэн зорилгоор хэрэглэхгүй байх явдал юм.

Судалгаанд оролцогчдын санал асуулгын хариултууд компьютерт нэгтгэгдэн орж, тэдгээрийг хэн өгсөн гэдгийг мэдэх боломжгүй болдог гэдгийг энгийнээр тайлбарлаж өгөх хэрэгтэй.

### **Шаардлагатай тохиолдолд туслалцаа үзүүл**

Судлаачид тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар мэдээллийн сантай байх ёстой. Мэдээлэл цуглуулахаас өмнө хохирогчдод үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагууд эсвэл тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын холбогдох мэдээллийг олж авсан байх ёстой. (Холбоо тогтоох хүмүүсийн нэр, утас, байршил зэргийг тэмдэглэсэн)

Хэрэв бид аюултай, эрсдэлтэй хохирогч болсон хүнтэй уулзаж буй бол түүнд туслалцаа үзүүлэх байгууллагын мэдээллийг дамжуулж, дахин хэрхэн холбогдож болох талаар мэдээллийг батжуулан цагдаагийн болон бусад мэргэжлийн байгууллагуудад хандах хэрэгтэй. Гэхдээ ийм асуудалд маш анхааралтай хандах хэрэгтэй бөгөөд зайлшгүй гэж үзсэн тохиолдолд багийн бусад гишүүддээ мэдэгдэн яаралтай шууд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах ёстой. Тухайлбал: Үйлчлүүлэгч танаас энэ миний сүүлчийн боломж, та надад туслалцаа үзүүлээч г.м хүсэлт тавьж буй нөхцөлд орхиж явах нь ёс зүйн хувьд болон тухайн хүний аюулгүй байдалд хүндрэл учруулж, эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай.

### **Хэрвээ тухайн хүнд бодит аюулд орох нь тодорхой байвал туслахад бэлэн бай.**

- Бодитойгоор хэрэгжих сонголтыг авч үз, түүнийг хэт бүү үнэл. Ярилцлага авч буй хүн тусламж үзүүлэх ямар боломж өөрт нь байгаа талаар ярилц, уг ярилцлага өгөгчид туслах талаар ярилцахдаа боломжтой гэсэн сонголтуудын үр өгөөж, эрсдэлийг тус бүр дээр нь авч хэлэлц.
- Ярилцлага авч буй хүн тухайн хүнд тусламж авах боломжтой бүх эх сурвалжид хүрэх нөхцөлийг хангахыг хичээх хэрэгтэй (жишээ нь тусламж үзүүлэх байгууллагын утасны дугаарыг өгөх, тэнд хүргэж өгөх).
- Хэрэв насанд хүрээгүй хүүхэд туслалцаа хүсэж байгаа тохиолдолд шууд судалгааны багийн гишүүдтэйгээ хамтран аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулна.

### **Осолтой болон ухаалаг бус алхмууд:**

- Тухайн мэдээлэл өгч буй хүнтэйгээ хамт “зугатах”;
- Судалгаа авч буй хүн түүнийг гэртээ авчрах;
- Түүний хувийн эд зүйлийг авахаар гэрт нь эсвэл ажлын байранд нь дагаж очих;
- Тухайн хүнийг ажил олгогч, найз залуу, зуучлагч болон хамт ажиллагсадтайгаа ямар нэг асуудал ярилцахад нь туслах зуучийн үүрэг ямар нэг байдлаар гүйцэтгэх.

### **Судалгаанд оролцогчдод хохирол учруулахаас зайлсхийх**

Судалгаа хийж байгаа хүмүүс бүх оролцогчдыг судалгаанд оролцсоны улмаас тэдэнд учирч болох аливаа биеийн болон сэтгэл санааны хохирлоос хамгаалж тэдний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.

Хохирол гэдэг нь зөвхөн биеийн хувьд учруулсан шарх биш юм. Хэрэв судалгаа нь мэдээллийг буруу үнэлж мэдээлсэн тохиолдолд олон нийтийн буруушаалт, айдас, ичгүүр, гэмт хэрэгтнүүдийн хонзогнол гэх мэт илүү ноцтой аюулд орно. Түүнээс үүдсэн дарамт нь сэтгэл санааны хүнд хор хохирол учруулдаг. Тухайлбал: Биеэ үнэлэгчдийн 60% нь багш нар байсан гэсэн мэдээллийг судалгааны тайлан эцэслэн гаргахаас өмнө мэдээлснээс тухайн орон нутгийн багш нар эцэг эхчүүдийн эсэргүүцэлтэй тулгарч ажлаа хийж чадахаа больжээ. Бодит байдал дээр 60 биеэ үнэлэгчээс авсан судалгаанд урьд нь багш хийж байсан 4 эмэгтэй хамрагдсаныг ташаа мэдээлснээс дээрхи нөхцөл үүсчээ.

### **Судалгаанд оролцогчдод хүндэтгэлтэй хандах**

Ёс зүйн судалгааны чухал хэсэг бол оролцогчдод хүндэтгэлтэй хандах явдал байдаг. Үүнд хувь хүн болон нийгмийн бүлгийн ёс заншил, уламжлалд мэдрэмжтэй хандах хандлага багтдаг. Судалгаанд оролцогчдод хүндэтгэлтэй хандахын тулд судалгааны баг дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг урьдчилан судалж хамгийн тохиромжтой хувцаслалт, биеэ авч явах маяг болон хэл яриагаа бэлдэх хэрэгтэй. Энэ нь зөвхөн судалгаанд оролцогчдод хүндэтгэлтэй хандаж байгааг харуулаад зогсохгүй тэднийг биеэ барихгүй чөлөөтэй байхад туслах юм.

Үйл хөдлөл бол үгнээс илүү зүйл бөгөөд хүмүүс биеийн хөдөлгөөнөөр асар их зүйл ойлголцдог. Судалгааны оролцогчдод үзүүлэх хүндэтгэл нь үгээр илэрхийлэгдэж болох ба мөн царайны хөдөлгөөнөөр тэдэнд шүүмжлэлгүй нөхөрсөг хандаж буйгаа илэрхийлж болно.

### **Урамшуулал**

Судалгаанд оролцуулахын тулд мөнгө амлах нь урт хугацааны турш ёс зүйн маргааны сэдэв болсоор ирсэн юм. Судалгаанд оролцогч хүүхэд болон насанд хүрсэн хүний аль аль нь судалгаанд оролцохын тулд цаг зав гаргах хэрэгтэй болдог ба заримдаа ирж очихдоо тээврийн хэрэгсэлд мөнгө зарцуулах болдог тул нөхөн төлбөр хийгдэх болдог. Мөнгө төлөх болон нөхөн олговор олгох асуудлыг урьдчилан тал талаас нь сайн бодож үзэх хэрэгтэй.

### **Судалгааны багийн аюулгүй байдал**

Аливаа судалгаа нь бүх оролцогчдынхоо болон судалгааны багийнхаа гишүүдийн бие, сэтгэл санаа болон аюулгүй байдлыг хамгаалах ёстой байдаг. Судалгаа явуулах газар нь

судалгааны багынханд аюулгүй юу?, хэрхэн аюулгүй байдлаа хангах вэ? гэдгийг боломжтой эх сурвалжаас авсан мэдээллээ нэгтгэн хүмүүстэйгээ зөвшилц. Судалгааны мэдээлэл цуглуулах “Баг” тус бүрт өөр өөр байна. Үүнд ахлах судлаачид, санал асуулга авагчдаас бүрдсэн багаас гадна нөөц хүмүүс байх эсвэл зөвхөн удирдах судлаачид л байж болно. Зарим тохиолдолд аюулгүй байдлаа хангуулах хүнийг судалгааны багт оруулж болно.

### **Ёс зүйн дүрмээ баримтлах.**

Санал асуулга авагчид ёс зүйн хүндрэлтэй байдал үүссэн үед хэнд хандах болон яаж ажлаа цааш нь үргэлжлүүлэх талаар мэдэж байх хэрэгтэй.

Нууцлалыг зөрчих хэрэгтэй бол урьдчилан болгоомжлох арга хэмжээ авах шаардлагатай. Хэрэв санал асуулга авагчид хүүхэд, эмэгтэйчүүдийг илэрхий тэсвэрлэшгүй нөхцөл байдалд байгааг олж мэдвэл:

- i) тэдэнд зөвлөгөө өгөх болон туслалцаа үзүүлэхийг санал болгох уу?
- ii) холбогдох хуулийн байгууллагыг оролцуулах уу?
- iii) бусад ТББ-ыг татан оролцуулах уу?
- iv) ХХГХ-ийн талаарх мэдээллийг өгөх үү?
- v) Яаралтай шууд туслалцаа үзүүлэх үү?

Бүх санал асуулга авагчид эдгээр асуудлыг хэрхэн шийдэхээ урьдчилан бэлдсэн байх хэрэгтэй. Мөн судлаач тус бүртэй холбоо барих утасны жагсаалт, яаралтай тусламж хэрэгтэй үед шууд холбогдох утасны жагсаалт, туслалцаа үзүүлэх байгууллага, хүмүүсийн мэдээллийг гар дороо байлгах шаардлагатай. Судлаач нь судалгаанд оролцогч эрсдэлд орсон нь илэрхий нөхцөл байдалд байхыг мэдвэл таслан зогсоох арга хэмжээ авах ёс суртахууны үүрэг хүлээдэг.

### **Судалгааны арга хэрэгслүүдийг турших**

Энэ нь хэл яриа тохиромжтой байгаа эсэх, асуултууд утга учиртай байгаа эсэх, ярилцлагыг зогсолтгүй явуулах хялбар арга хаана байна гэдгийг тогтооход ач холбогдолтой. Энэ нь мөн хүүхдүүдийг илүү идэвхитэй оролцуулах боломж юм. Тэд ямар үг хэллэг хэрэглэвэл зохих, асуултын бүтэц ямар байвал зохих талаарх өөрсдийн санаа оноог хэлж өөр ямар аргуудыг оронд нь хэрэглэж болох талаар саналаа хэлэх боломжтой юм.

### **Судалгааны үр дүнг тайлагнах**



Ихэнхдээ судалгааны үр дүнгийн ил тод байдал нь нийгмийн бүлэгт ашиг тусаа өгдөг боловч өөр тохиолдолд эсрэг нөлөө үзүүлэх магадлалтай байдаг ба оролцсон нийгмийн бүлэг болон хүүхдүүдийг судалгаанд дахиж оролцохоос татгалзах байдалд хүргэдэг. Мэдээ баримт болон судалгааны үр дүнг хуваалцаж байгаа байгууллага хүмүүст болгоомжтой хандах хэрэгтэй. Эцэст нь хэрэв судалгааны үр дүнг оролцогчдод мэдэгдэнэ гэж амласан бол судалгааны тайлан хийж тэдэнд тараах үүрэгтэй.

### **СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

1. Судлаач нь судалгааны явцад хүний эрхийг дээдлэн ажиллана.
2. Насанд хүрэгчид болон хүүхэд (судалгааны зорилтот бүлэг) судалгаанд оролцох эсэхээ өөрсдөө шийдэх эрхтэй
3. Судлаач нь ярилцлага өгөгчийн чөлөөтэй сонгох эрхэд хүндэтгэлтэй хандаж, түүнийг ямарваа төрлийн дарамт, шахалтад оруулах ёсгүй.
4. Судлаач насанд хүрээгүй хүүхдээс ярилцлага авахдаа хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үзэл хандлагыг дээдлэн, түүний нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан үзнэ.
5. Судлаач нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэдтэй ажиллахдаа онцгой анхаарал, сонор сэрэмжтэй ажиллаж, туслалцаа үзүүлэх боломжийг эрэлхийлнэ.
6. Судалгаанд оролцогчдод хүндэтгэлтэй хандахын тулд судалгааны баг дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг урьдчилан судалж хамгийн тохиромжтой хувцаслалт, биеэ авч явах маяг болон хэл яриагаа бэлдэх хэрэгтэй
7. Судалгаа хийж байгаа хүмүүс бүх оролцогчдыг судалгаанд оролцсоны улмаас тэдэнд учирч болох аливаа биеийн болон сэтгэл санааны хохирлоос хамгаалж тэдний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.
8. Ярилцлага авч буй хүн тухайн хүнд тусламж авах боломжтой бүх эх сурвалжид хүрэх нөхцөлийг хангахыг хичээх хэрэгтэй (жишээ нь тусламж үзүүлэх байгууллагын утасны дугаарыг өгөх, тэнд хүргэж өгөх).
9. Хэрэв насанд хүрээгүй хүүхэд туслалцаа хүсэж байгаа тохиолдолд шууд судалгааны багийн гишүүдтэйгээ хамтран аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулна.

## БҮЛЭГ 2

Хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон, эсвэл эрсдэлд байна гэж үзсэн хүүхэд, эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэхэд баримтлах зарчим

## **ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧООС ЯРИЛЦЛАГА АВАХАД МӨРДӨХ ЁС ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРВАН ҮНДСЭН ЗАРЧИМ**

### **1. ХОР ХОХИРОЛ БҮҮ УЧРУУЛ**

Хохирогч бүрийг, тухайн нөхцөл байдалд аюулгүй гэдгийг нотлох боломжгүй байгаа бол өндөр эрсдэлтэй гэж үзэх хэрэгтэй. Ярилцлага нь хохирогчийн нөхцөл байдлыг богино болон урт хугацаанд дордуулна гэж үзвэл ярилцлага бүү ав.

### **2. ЯРИЛЦАГЧАА САЙН СУДАЛЖ, ХАМТДАА БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙГ ДҮГНЭН ЦЭГНЭЖ ҮЗ**

Ярилцлага хийхийн өмнө хохирогч болсонтой холбоотой ямар эрсдэл гарч болохыг сайтар судалж мэд.

### **3. ЦААШИД ЯМАР БАЙГУУЛАГАД ХАНДАХ ТУХАЙ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭ, БИЕЛҮҮЛЖ ЧАДАХГҮЙ АМЛАЛТ БҮҮ ӨГ.**

Хууль, эрүүл мэнд, хамгаалах байр, нийгмийн халамж дэмжлэг, аюулгүй байдлын талаарх мэдээллийг тухайн хохирогчид өгөхөөр бэлтгэх хэрэгтэй. Түүнчлэн хэрвээ өөрөө хүсвэл цаашид аль нэгэн байгууллагад шилжүүлэн өгөх талаар туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

### **4. ОРЧУУЛАГЧ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮМҮҮСЭЭ ЗОХИХ ЁСООР СОНГОЖ, БЭЛТГЭХ** **Орчуулагчтай ажиллахын эрсдэл болон ач тусыг сайтар цэгнэж үзэхийн сацуу тэдгээрийг сонгон шалгаруулах, сурган бэлтгэх арга замыг боловсруулах**

### **5. ЯРИЛЦАГЧИЙН НЭР, ЯРЬСАН ЗҮЙЛИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ**

Ярилцагчтай холбоо тогтоохоос эхлээд түүнтэй холбогдох асуудлын нууцыг ярилцлага хийж буй хугацааны туршид чанд нууцлан хамгаалж, хадгалах хэрэгтэй.

**6. ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАСНЫ ДАРАА ЯРИЛЦЛАГА ӨГӨХ  
ЗӨВШӨӨРЛИЙГ НЬ АВ**

Ярилцлагын явцад юун тухай ярих, ямар зорилгоор ярилцаж байгаа болон тухайн мэдээллийг ямар зорилгоор ашиглах, зарим асуултад хариулахгүй байж болох, түүнчлэн дуртай цагтаа уг ярилцлагыг таслан зогсоох мөн түүнээс авсан мэдээллийг хэрхэн ашиглах болон үүнд хүрээ хязгаар тогтоох эрхтэй гэдгийг ярилцагч сайтар ойлгосон байх ёстой,

**7. ТУХАЙН ХОХИРОГЧ ӨӨРИЙН НӨХЦӨЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛДАА ӨГЧ БҮЙ  
ҮНЭЛГЭЭГ АНХААРАЛТАЙ СОНСОЖ, ТҮҮНД ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНД**

Хохирогч бүрийн санаа зовж буй асуудлууд хоорондоо адилгүй бөгөөд түүний сэтгэл зовоосон асуудалд хандах хандага үзэл бодол бусад хүмүүс үүнийг нь хэрхэн үнэлэн дүгнэж байгаагаас өөр, ялгаатай байж болно.

**8. ХУДАЛДАГДСАН ХОХИРОГЧИЙГ СЭТГЭЛ САНААНЫ ЦОЧРОЛД БУЦААН  
ОРУУЛАХГҮЙ БАЙХ**

Хохирогчид сэтгэлийг нь хэт их хөдөлгөж, догдлуулах асуулт бүү тавь. Тухайн хохирогчийн гуниг зовлонг багасгаж, өөрт нь байгаа давуу тал, боломж бололцоог тодруулан харуул.

**9. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ ХЭРЭГТЭЙ**

Хэрвээ ярилцагчид аюул тулгарч байгаа бол зохих арга хэмжээ авах бэлтгэлтэй бай.

**10. ЦУГЛУУЛСАН МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭ САЙН АШИГЛАХ НЬ**

Ярилцсан хохирогчид төдийгүй нийт худалдагдсан хүүхэд, эмэгтэйчүүдэд туслах бодлого, үр өгөөжтэй арга замыг боловсруулах замаар *öbãëóóëñàí* *ì*дээллийг ашиглах хэрэгтэй.

## **ЯРИЛЦЛАГА ХИЙХ ШИЙДВЭР ГАРГАХ НЬ**

Ихэнх ёс зүйн талаарх үндсэн чиглэлийн анхны зарчим нь “Ярилцлага өгөгчид хор учруулахгүй” байх юм. Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэхтэй холбогдсон онцгой их эрсдэлээс үүдэлтэйгээр энэ үндсэн дүрэм асар их ач холбогдолтой билээ.

### **Зөвлөмж**

Ярилцлага авах хүсэлт тавих эсвэл ярилцлага хийх нь тухайн эмэгтэйд хор хохирол учруулах болон уг эмэгтэйн аюулгүй байдал, сэтгэл санаанд муугаар нөлөөлөхөөр байгаа бол ярилцлага хийх хэрэггүй.

### ***АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТАВИХ АСУУЛТЫН ЗАГВАР***

*А: "Надтай энэ ярилцлагыг хийхэд таныг санааг зовоож байгаа ямар нэг асуудал байна уу?"*

*А: "Надтай ярилцсны улмаас танд ямар нэг асуудал бэрхшээл тулгарах уу?"*

*А: "Та урьд өмнө энэ талаар хэн нэгэнтэй (ярилцлага авдаг мэргэжлийн хүмүүстэй) ярилцаж байсан уу? Тэр ярилцлага танд ямар санагдсан бэ?"*

## **УЧИРЧ БОЛОХ ХОХИРЛЫН ЦАР ХҮРЭЭГ ОЙЛГОХ НЬ**

### **Эрсдэл**

Хүүхэд, эмэгтэйчүүдийг гартаа оруулсан гэмт хэрэгтнүүд бусадтай харилцах зоригийг нь мохоох зорилгоор айлган сүрдүүлдэг, зодож залхаан цээрлүүлдэг (зодох, хүчиндэх, хорьж цагдах зэргээр) бөгөөд эсвэл санхүүгийн хувьд залхаан цээрлүүлдэг (дуулгаваргүй байсных нь төлөө авах өр төлбөрөө нэмэх зэргээр) байна. Түүнчлэн ажиллах цагийг нь уртасгах, амрах, унтах цаг, хоол хүнс зэрэг наад захын үйлчилгээ авах “эрх”-ийг нь хасах зэрэг арга хэмжээ авдаг байна. Тогтоосон журмыг зөрчсөн гэгдэж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийг ингэж хашраах, шийтгэх нь бусдад нь анхааруулга сануулга болдог ажээ.

Худалдагдсан хүүхэд, эмэгтэйчүүд зөвхөн гэр бүлийнхнээсээ айгаад зогсохгүй, эцэг, эх, эр нөхөр нь мөн бусад хүмүүс түүнийг биеэ үнэлэгчээр ажиллаж байсан эсвэл бэлгийн хүчирхийлэлд автаж байсныг олж мэдээд яах бол гэж санаа зовдог.

Эцэг, эх, төрөл төрөгсөд, хань ижил нь юу болсныг олж мэдээд тухайн хүүхэд, эмэгтэйчүүдийг буруушаан зэмлэх, зодож нүдэх эсвэл бүр хөөх тохиолдол цөөнгүй гардаг.

## **ЯРИЛЦАХ ХҮНЭЭ САЙН МЭД, ЭРСДЭЛИЙГ ЦЭГНЭЖ ҮЗ**

### **ЭРСДЭЛ БА ЗӨВЛӨМЖҮҮД**

Ярилцлагын үе шат бүгд ярилцлага өгч буй хүний хувьд эрсдэлтэй байх болно. Үүнийг хүлээн зөвшөөрч, үнэлж үзээд аюулгүй байдлыг нь хангах зохих хэмжээний арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх шаардлагатай.

Тухайн хүүхэд, эмэгтэйчүүдийг эрсдэлд оруулах, илчлэхээс зайлсхийхийн тулд энэ тухай хэн нэгэн сонирхож асуувал ярилцлага авах хүн “эрүүл мэнд” зэрэг гэм зэмгүй жирийн асуудлыг хөндөх болно гэж хэлж болох юм. Тэгээд ярилцлага өгөгчтэй хоёул үлдсэний дараа ярилцлагын үнэн шинж чанарын талаар илүү нарийн мэдээллийг өгч, ярилцлага өгөх хүн (субъектыг) холбогдох мэдээлэл авч учрыг ойлгосны үндсэн дээр ярилцах зөвшөөрлөө өгөх журмыг мөрдөж ажиллах хэрэгтэй.

### **Ярилцлага хийх цаг хугацаа, байраа сонгон тогтоох нь:**

#### **Эрсдэл**

ХХГХ үйлдэгчид хүүхэд, эмэгтэйчүүдийг гаднын хэн нэгэнтэй уулзахад түүний хойноос дагах, ажиглах, яриаг нь сонсох ажиллагааг заавал явуулдаг. Зарим тохиолдолд тэдний ажлын байр, байр сууцанд нь дүрс бичлэгийн аппарат ч тавьсан байдаг.

#### **Зөвлөмж**

Ярилцлагыг хүмүүс хажуугаар холхих эсвэл санамсаргүй байдлаар “орж гарах” зэргээр яриаг тасалдуулвал ярилцлага өгч байгаа хүн эвгүй байдалд орох болно. Мөн хүүхдийн дэргэд ярилцлага хийх нь тухайн эмэгтэйг сэтгэлийн зовлон, цоцролд оруулж болох талтайгаас гадна ярьсан хэлснийг нь бусдад хэлж дамжуулахад хүргэж болзошгүй. Ярилцлагын өмнө эсвэл ярилцах явцдаа тухайн ярилцагч өөртөө илүү таатай, аюул багатай байхаар зохион байгуулах хэрэгтэй.

### **Ярилцлага хийхээр ирэхдээ өмнөх хэвшмэл бодол төсөөллөө орхиж, юу ярихыг нь сонсох бэлтгэлтэй ир**

#### **Эрсдэл**

Ярилцах хүнийхээ талаар урьд өмнөөс тогтсон төсөөлөлтэйгөөр, эсвэл бусадтай жишиж хандвал түүний туулж өнгөрүүлсэн амьдрал, өөрийн бодол, байр суурь, зан араншингийн талаар болон бусад чухал мэдээ мэдээллийг, амьдралын чухам юу хосгүй онцлог байсныг анзаарч хайхралгүй өнгөрөөх болно.

### **Зөвлөмж**

Хэдийгээр ямар асуулт тавихаа бодож төлөвлөх нь чухал боловч чөлөөтэй илэн далангүй яриаг ярилцлага авч буй хүн нэг талыг барилгүй, тэвчээртэй сонсох мөн түүний ухан ойлгох ур чадвараас ихээхэн хамаарна.

### **Ярилцагч өөрт нь аюул учирлаа гэж бодвол үүнийг анхаарах хэрэгтэй**

#### **Эрсдэл**

Ярилцлагын үед янз бүрийн юм гэнэт тохиолдож болно. Хэрвээ ярилцлагын нөхцөл байдал осолтой байдлаар өөрчлөгдвөл, Жнь: гаднын хүн орж ирэх, эсвэл ярилцагч асуудал гарлаа гэдэг дохио зангаа өгвөл ярилцлагыг шууд зогсоож уулзалтыг дуусгах яаралтай арга хэмжээ авахад бэлэн байх хэрэгтэй.

Хэдийгээр ярилцлага хийхээр урьдаас тохиролцсон газар боломжийн байсан ч ярилцагч тав тухаа алдаж, осолтой байдлыг мэдэрч эхлэх юмуу ярилцлагын явцад нэг л тавгүйтэж эхэлж байгаа нь харагдаж болно. Иймэрхүү дохиог дор нь тусган авах хэрэгтэй. Ярилцлагын шинж чанарыг эсвэл ярианы сэдвийг өөрчлөх дараах тохиолдлууд гарч болно. Үүнд:

- Хэн нэгэн өрөөнд орж ирэх буюу хажуугаар явж өнгөрөх;
- Ярилцлага авч байгаа хүн тодорхой хүний нэр, хаягийг хэлж өгөхийг хүсэх эсвэл гэр бүлийнх нь тухай мөн өөрийнх нь насыг асуух зэрэг нь түүнд сэжигтэй санагдаж, эргэлзэх сэтгэл түгших шалтаг болно.
- Ярилцлага авч байгаа хүн өөртөө итгэлгүй байх, сандарч тэвдсэн байдал гаргах .

### **Зөвлөмж**

Ярилцлага өгч байгаа хүний сэтгэл тавгүйтэж эхэлсэн мөн ярилцлагыг зогсоох хүсэлтэй байна гэсэн шинж тэмдэг мэдэгдэж байгаа эсэхийг анхааралтай ажиглах нь чухал байдаг. Хэрвээ тухайн ярилцлагчийн сэтгэлийг түгшээсэн ямар нэг зүйл гарвал анхаарлыг сарниулах зорилготой өөр янз бүрийн асуултад хариулах, ярилцаж буй сэдвээ өөрчлөхөд бэлэн байлгах хэрэгтэй.

### **Ярилцлагыг дуусгах: Ярилцлагыг өөдрөг эерэг өнгө аястай дуусгах хэрэгтэй.**

Цаашид тусламж дэмждэг шаардлагатай хүмүүст хандаж харилцах байгууллагуудын талаарх мэдээллийг өгч (хавсралтаас үзнэ үү) хэрвээ тухайн хүүхэд, эмэгтэйчүүд эдгээр байгууллагын тусламжийг хэзээ нэгэн цагт авахыг хүсвэл тэд үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байх болно гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

## **ХААНА ХАНДАЖ БОЛОХ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭХ:**

Хууль эрх, эрүүл мэнд, хамгаалах байр, нийгмийн халамж, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээний талаар холбогдолтой мэдээ мэдээллийг уг хүнд өгөх бэлтгэлтэй байх хэрэгтэй, хэрвээ хүсвэл тусламжийн байгуулагад хандахад нь тусалж болно.

## **ӨӨРИЙН БИЕЛҮҮЛЖ ЧАДАХААРГҮЙ АМЛАЛТ ӨГЧ БОЛОХГҮЙ**

### **Эрсдэл**

Өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд тустай мэдээлэл олж авах боломж хүний наймаанд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд хомс байдаг. Ярилцлагад оролцоно гэдэг нь тухайн хүүхэд, эмэгтэйчүүдийн хувьд мэдээлэл олж авах сайхан боломж байх болно. Энэ нь хүний амь насыг аврах тусламж байж болох учраас ярилцлага авагчийн нэн чухал үүрэг хариуцлага юм.

### **Зөвлөмж**

"Нөөц бололцоо бэлэн байх шаардлагатай." Дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх ямар байгууллагуудад хандаж болох талаар мэдээлэл өгөх нь тухайн хүүхэд, эмэгтэйчүүдийг тусламж авах амин чухал эх сурвалжтай болгоод зогсохгүй ярилцлага авч буй хүнд улам их найдвар тавьж итгэхэд дөхөм үзүүлнэ. Уг ярилцлага өгөгчид тохиолдсон зүйл нь түүний буруу биш гэдгийг батлан ярьснаараа түүнийг тусламж авъя гэсэн урам зоригийг төрүүлж чадна. Мэдээллийг маш товч бөгөөд тодорхой байдлаар танилцуулах хэрэгтэй.

## **ХАНДАЖ БОЛОХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТЫГ ГАРГАЖ, ТЭДЭНТЭЙ ХОЛБОО ТОГТООХ**

### **Эрсдэл**

Хэрвээ дээрх байгуулагын талаарх мэдээлэл аль нэг эмэгтэйд байгааг тэднийг зуучлагчид, ажил олгогчид нь олж мэдвэл түүнд аюултай байж болох ба гэр оронд нь ийм мэдээлэл байвал гэр бүлийн гишүүдэд нь мөн асуудал бэрхшээл мөн үүсэж болох талтай.

### **Зөвлөмж**

Хандаж холбоо барьж болох байгуулагуудын тухай мэдээллийг урьдчилан нэг жижиг хуудас дээр хэвлэн бэлтгэвэл тохиромжтой. Учир нь ярилцлагын дараа уг эмэгтэй авсан мэдээллийн тусламжтайгаар шаардлагатай үедээ ашиглахаар нууцлан



хадгалах боломжтой байх болно. Түүнд хэр хэмжээний буюу ямар ямар тусламж үйлчилгээ үзүүлэх талаар аль болох тодорхой мэдээлэл оруулсан байх хэрэгтэй. Уг хуудас дээр чухам ямар зориулалттайг нь дурдалгүй зөвхөн хаяг, утасны дугаар ч байж болно.

## НУУЦЛАЛЫГ ХАНГАЖ ХАМГААЛАХ

### Эрсдэл

Нууцлалыг хамгаалах нь ярилцлага өгч буй хүний аюулгүй байдал, түүний өгч буй мэдээллийн чанар чансаанд маш чухал ач холбогдолтой юм.

### Зөвлөмж

- Ярилцлагыг тухайн хүн хэн болох, түүний тухай мэдээллийг чанд нууцлан хамгаална гэдгийг тайлбарлан хэлэхээс эхлэх хэрэгтэй. Энэ бүхэн хангалттай гэж бодож байгаа эсэхийг түүнээс мөн асуу.
- Өөрийн жинхэнэ нэрийг хэлэхгүй байж болно (эсвэл хуурамч нэр хэрэглэж боно) мөн төрсөн аймаг, хот, сумаа нууцалж болно гэдгийг хэлэх хэрэгтэй. Зөвхөн ярилцлага өгсөн эмэгтэйн зөвшөөрлөөр зайлшгүй шаардлагатай үед л хийх болно.
- Ярилцлагын агуулгын талаарх хэлэлцүүлгийг гаднын хүн сонсож болохоор нөхцөлд болон олон нийтийн өмнө хэзээ ч явуулж болохгүй.
- Ярилцлагын агуулгын талаар олон нийтийн болон гаднын хүмүүс сонсож болох газарт ярьж хэрхэвч болохгүй!
- Хэрвээ ярилцлагыг соронзон хальсанд бичиж байгаа бол хүний нэрний оронд зөвхөн тусгай кодыг ашиглах хэрэгтэй. Бичлэгийг цөөн тооны нэр бүхий хүмүүс үзэж болохоор цоожтой саванд хадгалах бөгөөд цаасан дэр буулгасны дараа арчиж устгана.
- Ярилцлагын агуулгыг нийтлэх, олон нийтэд мэдээлэхдээ тухайн хүний биеийн байцаалтыг түүнийг таних аргагүй, хангалттай сайн өөрчлөх хэрэгтэй. Жишээ нь: хэвлэх материалд төрсөн газар, ажил, мэргэжил, гэр бүл, найз нөхдийн нэрийг бичиж болохгүй. Түүнчлэн очсон газрын нэрийг ч өөрчлөх хэрэгтэй.

*Нэгэн кино найруулагч хүний наймааны золиос болсон эмэгтэйчүүдийн тухай баримтат кино хийж, худалдагдсан хэд хэдэн эмэгтэйн мэдүүлгийг кинонд оруулжээ. Найруулагч уг киногоо зөвхөн гадаадад үзүүлэх зорилготой байсан аж. Гэтэл удалгүй уг баримтат киног үндэсний телевизээр гаргаж нөгөө эмэгтэйчүүдийн нүүр царайг бүтнээр нь харуулсан байна.*

## ЯРИЛЦАГЧИЙН НЭР, ЯРИАНЫ НУУЦЫГ ХАМГААЛАХ

Ярилцлага өгөх хүн, түүнтэй холбогдох бүх мэдээллийн нууцыг тухайн хүнтэй уулзсан цагаас эхлэн уг хэрэг олон нийтэд ил болтол нууцлан хамгаалах ёстой.

## **ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХЫГ ЗОХИМЖТОЙ БАЙДЛААР ХҮСЭХ НЬ**

### **Эрсдэл**

Хохирогч болсон хүүхэд, эмэгтэйчүүд гаднын хүмүүст сэжиглэнгүй болгоомжтой ханддаг нь ойлгомжтой. Зарим нь гарах үр дагаврыг тооцохгүйгээр шууд зөвшөөрлөө өгчихдөг.

### **Зөвлөмж**

Ярилцлага нь зарим асуудлаар хувь хүний асуудлыг хөндсөн мэт санагдах үед сэтгэл санааны хувьд бага зэрэг шаналгаанд орж болзошгүйгээс гадна нэгэнт өгсөн бол буцаан авч болдоггүй учраас ярилцлага авч байгаа хүн энэ бүгдийг сайтар тайлбарлан ойлгуулах нь маш чухал юм. Үүнд:

- ярилцлага хийж байгаа шалтгаан;
- ярилцах сэдэв;
- үүнд оролцсонтой холбоотой болзошгүй эрсдэл болон үр өгөөж; түүнчлэн
- өөрийнх нь талаар тавих асуултууд магадгүй хэтэрхий хувийн чанартай, магадгүй

Ярилцлага авч буй хүн нь ямар ямар төлөвлөгөөтэй, яах гэж тухайн асуултыг тавьж байгааг бүрэн сайн ойлгосон бол өгч буй мэдээллийг өөрийнх нь эсрэг ашиглана, хор хохирол учруулна гэж санаа зовохгүй байх болно.

санаа зовмоор ч шинж чанартай байж болно гэдгийг хэлэх.

- Ярилцлага авсны төлөө бага хэмжээний мөнгөн урамшуулал өгсөн байвал мөнгөө нуусныг нь (халаасны буюу цайны мөнгө г.м) ажил олгогч, зуучлагчид эсвэл хүний наймаачид олж мэдвэл тэр нь түүнийг цээрлэн шийтгэх шалтгаан болох талтай. Иймд түүнээс бэлэн мөнгө эсвэл материалын урамшуулал (жишээ нь ариун цэврийн хэрэгсэл, саван, шампунь, бэлгэвч, хоол хүнс, хувцас бусад зүйл) авах уу, эсвэл мөнгийг гэр бүлд нь илгээх эсвэл холбоо барьдаг итгэлтэй хүнд нь өгөх үү гэдгийг асууж лавлах хэрэгтэй.
- Бололцоотой нөхцөлд (өөрөөр хэлбэл энэ нь ямар нэг аюулгүй бөгөөд ярилцлага өгөгч үүнийг хүсэж байгаа бол), хэрвээ дараа дахин уулзахад ямар нэг осол аюулгүй гэж үзэж байгаа бол тэр хүүхэд, эмэгтэйтэй эргээд харилцаа барьж (жишээ нь сонины өгүүлэл, судалгааны үр дүн, хөтөлбөрийн сурталчилгаа, үйл ажиллагааны танилцуулга г.м) хүссэн материалыг нь өгч болох юм.

## **ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХЭЭР АМЛАХ ТАЛААР**

### **Эрсдэл**

Ярилцлага авч байгаа хүн сайн санаж тухайн ярилцлага өгөгчийн хувьд яасан нь дээр вэ гэдгийг өөрийгөө мэдэж байна гэж төсөөлөн зөвлөгөө өгөхөөр шийдэх, ямар нэг арга хэмжээ авахаар өөрийн бодсон алхмыг хий гэж ятгах байдал гаргаж магадгүй. Хэдийгээр сайн санаад ингэж ятгах, ямар нэг алхам хий гэж шавдуулж байгаа ч (Жишээлбэл: хүний наймаачдаас оргон зугтах, хууль хяналтынхантай холбоо барих, тухайн гэмт хэргийг илчлэх) тухайн нөхцөл байдлын талаар урьд нь нухацтай сайн ярилцаагүй бол үүний үр дагавар хор хөнөөлтөй байх болно.

### **Зөвлөмж**

- Ямар нэг зөвлөгөө өгөх, тодорхой алхам хийхийн өмнө тухайн ярилцагч өөрийн нөхцөл байдлыг юу гэж үзэж байгаа, түүнд ямар боломж гарц байгаа, эдгээртэй холбогдсон болзошгүй эрсдэл, үр өгөөж ямар байх болно гэж үзэж байгаа болон эдгээр алхам өөрчлөлтийг хийх тохиромжтой цаг хугацаа хэзээ гэж бодож байгаа талаар сайтар хэлэлцэн ярилцах хэрэгтэй.
- Мөн өнөөг хүртэл тулгарсан бэрхшээлийг давах, учирч болох хор хохирлыг зайлуулахын тулд ямар арга стратеги хэрэглэж ирснийг асууж лавлах нь ярилцлага авч буй хүн тухайн эмэгтэйн амьдарч байгаа бодит нөхцөл байдлыг илүү сайн ойлгоход тус дөхөм үзүүлнэ.
- Ярилцлага авч байгаа хүн уг эмэгтэйд өгөх зөвлөгөө, туслах боломж байна гэж үзвэл түүнийгээ аль болох төвийг сахисан байдлаар хэлж өгөх, тусламж үзүүлэх магадлал, боломжийг хэтэрхий дөвийлгэхгүйгээр тайлбарлан таниулах хэрэгтэй.
- Эдгээр хувилбаруудыг тухайн ярилцагч хүлээн авах хүсэлгүй байгаа бол түүнийг хүний тусыг бодоогүй, тэнэг мэт эвгүй байдалд оруулахгүйн тулд сэтгэлийн хөдөлгөөн багатай энгийн байдлаар танилцуулах нь зүйтэй.
- Хүний наймааны хохирогчтой уулзсан ярилцлага авагч түүнийг аврах арга замыг хайдаг нь жирийн үзэгдэл билээ. Мэргэжлийн бус буюу албан бус аврах ажиллагаа нь энэ нөхцөл байдлаас ангижирсны дараа гарах болзошгүй үр дагавар, түүний цар хүрээг бүрэн ойлгоогүйн улмаас аврагдаж буй хохирогчийн хувьд хангалттай биш байх тохиолдол олон гардаг ихээхэн эрсдэлтэй хувилбар юм.

## **ТУХАЙН ЯРИЛЦАГЧ ӨӨРИЙН НӨХЦӨЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛД УЧИРЧ БУЙ ЭРСДЭЛД ӨГЧ БАЙГАА ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТЭД АНХААРАЛ, ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНД**

Хохирогчийн санаа зовох асуудал бүгд хоорондоо ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөр, түүнчлэн санаа зовж буй асуудалдаа хандах хандлага нь бусад хүмүүс үүнийг хэрхэн дүгнэж цэгнэж байгаагаас ялгаатай байж болох юм.

Тухайлбал :

- үүнийг түүний өөрөө хийсэн сонголт, алхам гэж олон нийт үзэж, зэмлэн буруушаана;
- ийм байдалд орсон учир шалтгаанд эргэлзээтэй хандах;
- ер төлбөрөө төлж чадахгүй байх;
- зуучлагч найз залуугаас бүх харилцаагаа таслах үүрэг авах;
- цагдаад гэрчлэх, шүүх хуралд гэрчийн мэдүүлэг өгөх;
- Саатуулагдах, баривчлагдах, эрүүгийн хариуцлага хүлээх (өөрөөр хэлбэл биеэ үнэлсэн, хүнийг гүтгэсэн г.м үндэслэлээр);

## **ТУХАЙН ЯРИЛЦАГЧИЙН ӨӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН ХИЙСЭН СОНГОЛТОД ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНД**

### **Эрсдэл**

Хамгийн аймаар муухай нөхцөлд амьдарч байгаа эмэгтэй ч тусламж авахаас татгалзах сонголт хийж болно. Харин энэ байдлаас гарах “ямар нэг зүйл хийх” эрмэлзэлтэй байгаа хүний сонирхлыг эмнэлгийн тусламж үзүүлэх, хоол хүнс өгөх эсвэл тэндээс аврах санал ихэнхдээ тохиолдолд татдаг. Өмнө дурьдсанчлан түүний өмнөөс ямар нэгэн алхам хийхийн өмнө тухайн хохирогчийн зөвшөөрлийг заавал авах нь нэн чухал.

### **Зөвлөмж**

- Хүүхдийг хуулийн байгууллагын итгэмжлэгдсэн хүмүүстэй ярилцан яаралтай аврах ажиллагааг явуулах шаардлагатай.
- Насанд хүрэгчдийн хувьд аливаа тусламжийн үйл ажиллагааг явуулахдаа хичнээн аюул осолтой санагдсан ч заавал ярилцагчийн саналыг нь хүндэтгэн үзэх ёстой.
- Хүсээгүй байхад нь аврах оролдлого хийх, албаны хүмүүст хандах, гэр бүлийнхэнтэй нь холбоо тогтоох, мэдээллийг сэтгэл зүйн зөвлөгөө өгөх хүмүүст

дамжуулах зэргийг тэр бүр ойшоож үздэггүй бөгөөд энэ нь тухайн хүний ашиг сонирхолд тэр бүр нийцдэггүй талтай.

**Худалдаалагдсан байдлаас ангижирч гарах бодолтой хүүхэд, эмэгтэйчүүдтэй сайтар ярилцвал зохих асуудлууд:**

- Урьдаас сайн төлөвлөх нь чухал.
- Уг хохирогч хаана байрлах боломжтой болон хэрхэн амьдралаа залгуулах.
- Түүнийг хэн эрж хайх, түүнийг араас болон гэр бүлийнхнийг хэр ноцтой мөрдөж мөшгөх.
- Сэтгэл зүйн байдал, түүнд ямар тусламж хэрэгтэй болох.
- Уг хохирогчийн зуучлагч, эзэн зэрэг хүмүүстэй тогтоосон харилцаа тэднээс хэр их хамааралтай байдаг, тэндээс гарсны дараа түүнийг хэн асран халамжлах.
- Бусад үр дагаврууд

## **ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ СЭТГЭЛ САНААНЫ ЦОЧРОЛД ДАХИН ОРУУЛАХААС ЗАЙЛСХИЙХ НЬ**

### **Эрсдэл**

Дийлэнхи тохиолдолд үзэж туулсан айдас, гутаан доромжлол, шаналгаа зовиурын тухай яриулах нь түүний сэтгэлийг маш ихээр түгшээдэг. Олон хүүхэд, эмэгтэйчүүд өөрсдийн хийсэн болон түүнд тохиолдсон зүйлээс ичиж зовдог.

### **Зөвлөмж**

- Сэтгэл санааг нь маш ихээр хямруулах асуултыг хэзээ ч бүү тавь.
- Сэтгэл санааг нь илтэд хямруулах, амссан зовлонг нь ухаарч ойлгоход онцын шаардлагагүй санаа зовмоор нарийн ширүүн зүйлийг илчлэн ярих асуултыг хасах хэрэгтэй.
- Түүний гаргасан шийдвэр, хийсэн алхам, зан араншинг битүүгээр мушгин гуйвуулж буруутгасан агуулгатай асуултыг тавьж болохгүй. Жишээ нь:
  - Таны хийсэн зүйлийн талаар эх, эцэг чинь юу гэж бодох вэ?
  - Та яагаад үүнийг хийхийг зөвшөөрсөн юм бэ?
  - Та өөрийгөө ёс суртахуунгүй хүн гэж үзэж байна уу? г.м.
- Асуултыг өөнтөгч бус эелдэг байдлаар тавьж өгсөн хариултыг баталж дэмжсэн нааштай янзаар хүлээн авах хэрэгтэй.
- Ярилцагч хүнд ярилцлагын хэмнэл, чиглэлийг тогтоох боломж олгох хэрэгтэй.

### **ЯРИЛЦАГЧИЙГ СЭТГЭЛ САНААНЫ ЦОЧРОЛД ДАХИН БҮҮ ОРУУЛ**

Сэтгэлийг нь хөдөлгөж хямруулсан хариулт авах зорилготой асуултыг бүү тавь. Түүний зовиур шаналгааг хөнгөлж сэтгэлийн тэнхээг нь харуулахад бэлэн бай.

- Нүдний харц, дуу хоолойгоороо эерэг нааштай, өөнтөгч биш байдлаар хандаж буйгаа харуул.
- Зовж шаналсан үед ярилцлагыг түр зогоох, завсарлага авах зэрэг хариу арга хэмжээ ав.
- Ярилцлага авч буй хүн түүнд санаа тавьж байгаагаа харуулах, тийм хүнд бэрхийг амь мэнд туулж өнгөрсөн сэтгэлийн хаттай ухаалаг гэдгийг нь сануулах.
- Ярилцлага хийх үгүйг зөвхөн ярилцах хүн шийдэх ёстой. Ярилцлага авч буй хүн тийнхүү зовж шаналсан эмэгтэйг ярилцлагаа үргэлжлүүл гэж шахаж шаардаж хэзээ ч болохгүй. Түүнчлэн хэрвээ ярьж байгаа хүн ярилцлага авч буй хүн асуух асуултаа тавьж дууссан ч яриагаа үргэлжлүүлэх сонирхолтой байвал тэрээр идэвхитэй, анхааралтай сонсогч хэвээр байх хэрэгтэй.

## **ЯАРАЛТАЙ ТУСЛАХЫГ ГУЙСАН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ**

### **Эрсдэл**

Хүн худалдаалах зэрэг хүний эрхийг зөрчсөн гэмт хэргийн хохирогчид нэн яаралтай туслахыг гуйх нь олонтаа тохиолддог. Тэдэнд туслах нь хүний амь нас аврах төдийгүй ёс зүйн үүрэг. Гэхдээ тусламжийг буруу арга замаар, буруу цаг үед үзүүлбэл эсвэл тусламж амалсан хүмүүс эцсийн үр дүнд хүртэл хөөцөлдөх хүсэлгүй эсвэл тийм бололцоогүй байвал бүх зүйл буруугаар эргэх аюултай.

### **Зөвлөмж**

- Хэрвээ тусламж хүсвэл үүнийг ярилцлага хийхээс илүүтэйд үзэж яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй.
- Ярилцлага авч буй хүн ямар аюул тулгарч болох талаар тухайн ярилцагчаас, тэр өөрөө ямар боломж гарц байгаа гэж бодож байгаа мөн ямар тусламж авна гэж найдан хүлээж байгаа талаар асууж лавлах хэрэгтэй.

## **ЯАРАЛТАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХАД БЭЛЭН БАЙ**

**Хэрвээ тухайн хүүхэд, эмэгтэй юу юугүй аюулд орох гээд байна гэвэл туслахад бэлэн бай.**

- Бодитойгоор хэрэгжих сонголтыг авч үз, түүнийг хэт бүү үнэл. Ярилцлага авч буй хүн тусламж үзүүлэх ямар боломж өөрт нь байгаа талаар ярилц, уг хүнд туслах талаар ярилцахдаа боломжтой гэсэн сонголтуудын үр өгөөж, эрсдэлийг тус бүр дээр нь авч хэлэлц.
- Ярилцлага авч буй хүн тухайн хүн тусламж авах боломжтой бүх эх сурвалжид хүрэх нөхцлийг хангахыг хичээх хэрэгтэй (жишээ нь тусламж үзүүлэх байгууллагын утасны дугаарыг өгөх, тэнд хүргэж өгөх, судалгааны багийн гишүүддээ хандах г.м).

### **Осолтой болон ухаалаг бус алхмууд:**

- Түүнтэй хамт “зугатах”;
- Ярилцлага авч буй хүн түүнийг гэртээ авчрах;
- Түүний хувийн эд зүйлийг авахаар гэрт нь эсвэл ажлын байранд нь дагаж очих;
- Ярилцлагчийн ажил олгогч, найз залуу, зуучлагч болон хамт ажиллагсадтайгаа ямар нэг асуудал ярилцахад нь туслах зуучийн үүрэг ямар нэг байдлаар гүйцэтгэх.



## **ТУСЛАХ ХҮЧ ЧАРМАЙЛТАА ТУУШТАЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД БЭЛЭН БАЙХ**

### **Зөвлөмж**

Хувь хүнийг аврах хүч чармайлт нь нэг амьсгаагаар хийчих зүйл биш бөгөөд түүнийг цаашид хэрэгжүүлэх олон практик алхам шаардагддаг. Ялангуяа аврах ажиллагааны үед хамгийн энгийн хялбар хэсэг бол оргон зайлах нь олонтаа ч үүний дараа хэрэгжүүлэх алхмууд, тухайлбал тухайн хүүхэд, эсвэл эмэгтэйг асран хамгаалах зэрэг маш нарийн төвөгтэй ч зайлшгүй чухал зүйл байх болно.

### **Зөвлөмж**

- Түүнийг “оргоход” нь туслахын өмнө эцсийн бүлэгт тухайн хүний байдлыг бүр дордуулах эсвэл нөгөө л олзолсон хүмүүс дээрээ буцаж очихоос өөр замгүй болох байдалд хүргэхгүй тулд болзошгүй бүх эрсдэл, саад бэрхшээл, “аварсан”-ы дараа хэрэгжүүлэх олон алхмуудыг бүгдийг нь тооцож үзсэн байх шаардлагатай.
- Тиймээс судалгаанд гарахаас өмнө хүүхдийн хамгаалах байр, ХХГХ-ийн хохирогчийн хамгаалах байр зэрэгтэй урьдчилан тохиролцож, шаардлагатай үед бүх л үйлчилгээ туслалцааг цаг алдалгүй авна гэдгээ нарийн тохиролцох

## **ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБОО ТОГТООХ**

### **Эрсдэл**

Ихэнх хүүхэд, эмэгтэйчүүд хууль хяналтын байгууллагатай холбоо тогтооход дурамжхан байх болно. Тэд цагдаа зэрэг албаны хүмүүс хээл хахуульд автсан гэж айдаг бөгөөд тэдэнд туслахгүй харин ч дайсагнасан байдлаар хандана гэж эмээдэг.

### **Зөвлөмж**

- Албаны хүмүүстэй холбоо тогтоохын өмнө уг хүүхэд, эмэгтэйчүүд үнэхээр хүсч байна уу? гэдгийг сайн мэд.
- Албаны хүнтэй холбоо тогтоохын ашиг тус, эрсдэл болон төр засгийн байгууллагууд ямар тусламж үзүүлж чадахыг олж мэд (Жнь: бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд үзүүлэх туслалцаа, ХХГХ-ийн хохирогчийг аврах үйл ажиллагаа г.м).
- Энэ чиглэлээр дагнан ажилладаг цагдаагийн хүүхдийн алба, ЭЦГ-ын ЗБГХТ тасаг, УМБГ зэрэгтэй харилцаа холбоо тогтоохыг эрмэлз.

## **МЭДЭЭЛЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ АШИГЛАХ НЬ**

### **Эрсдэл**

Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдахаас үүдэлтэйгээр хувь хүнд, нийгэм болон эрүүл мэндийн салбарт учирч буй асар их гарз хохирол цуглуулсан мэдээ мэдээлэл нь зөвхөн ярилцсан хүнд үр ашгаа өгөхөөр хязгаарлагдалгүй бодлого боловсруулагчид энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийн анхааралд (хоёуланд нь бол сайн) заавал хүргэх үүргийг ярилцлага авч буй хүний өмнө тавьж байгаа юм.

### **Зөвлөмж**

- Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах болон тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлдэг бүлгүүдийг энэ ажилд татан оролцуулах нь ярилцлагын аюулгүй байдлыг хангах, ярилцлага хийх арга техник, мөн тус дэмжлэг үзүүлэх бүх системийг хамрах төдийгүй жинхэнэ хэрэгтэй мэдээлэл цуглуулахад ихээхэн тус дөхөм болдог.
- Ярилцлага авах хүн олон нийтэд хүргэж байгаа мэдээллийг буруу зөрүү тайлбарлах, улмаар ХХГХ-ийн хохирогчийг буруутгах хэвшмэл үзэл бодлыг улам дэвэргэх хандлагыг бий болгохгүй байх талаар онцгой анхаарах хэрэгтэй.

Мэдээллийг зөвхөн нэг хүнд туслахаас гадна хүний наймааны золиос болсон бусад хүүхэд, эмэгтэйчүүдэд туслах бодлого, үр өгөөжтэй арга замыг боловсруулах үйлст ашиглавал зохино.

### **ЦУГЛУУЛСАН МЭДЭЭЛЛЭЭ САЙН АШИГЛАХ ХЭРЭГТЭЙ**